

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНААС АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ 2017 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа /ХХААХҮЯ-наас төлөвлөсөн/
1.	Зорилт 1. шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянуулж, томилох
2.		ХАСУМ-ийг хянуулахдаа Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлтийг хүргүүлж хэвшүүлэх.
3.		Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох
4.		Албан хаагчдад тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилохоор дэвшүүлэх
5.		Төрийн захиргааны албан хаагчийг сэлгэн ажиллуулах
6.		Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, яамны цахим хуудаст болон дотоод сүлжээгээр дамжуулан албан хаагчдад танилцуулах
7.		Байгууллагын Ёс зүйн хороог байгуулан ажиллуулж, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах,
8.		Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор саналын хайрцаг болон ХХААХҮЯ-ны цахим хуудаст булан ажиллуулах
9.		Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг ХХААХҮЯ-ны цахим хуудаст тогтмол хугацаанд мэдээлэх
10.		АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох
11.		Яамны төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах төлөвлөгөөг батлуулж мөрдүүлэх.
12.	Зорилт 2. төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ буюу Хэрэглэгчийн үнэлгээ хийлгүүлэх.
13.		Байгууллагын хэмжээнд төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх
14.	Зорилт 3. төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах,	Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, зарцуулалтын байдалд дүн шинжилгээ хийж, хариуцлагыг дээшлүүлэх
15.	ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай,	“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээллийг цаг тухайд нь хөтлөх.
16.	зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;	Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах

17.		Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжтой байх зорилгоор цахим хуудсыг нээн ажилуулах.
18.		Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн дотоод аудитын хяналтын хараат бус байдлыг хангаж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох
19.		Аудитын байгууллагын акт, дүгнэлтийг байгууллагын цахим хуудаст байршуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх
20.	Зорилт 7. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт,	Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах
21.	иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх
22.	дэмжих;	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх
23.		Яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлтэй хамтран ажиллах.
24.	Зорилт 10. шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор албан хаагчдад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах
25.	ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;	Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, байгууллагын цахим хуудаст байршуулж, хэрэгжилтийн үр дүнг сайжруулах

.....оОо.....